

**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 09 сарын 18

№1

Улаанбаатар хот

Компанийн дүрмийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, дахь заалт болон Эм жи эл акуа ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 09 сарын 18-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Эм жи эл акуа” хувьцаат компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлээс Моторт тээврийн хэрэгслийн худалдаа, Хүнс, ундаа тамхины бөөний худалдаа чиглэлийг тус тус хасаж, компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлд Ундаа усны үйлдвэрлэл, Катерингийн үйлчилгээ, Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлийг нэмсүгэй.
2. “Эм жи эл акуа” хувьцаат компанийн дүрмийг энэхүү тогтоолын Хавсралт №1 -р баталсугай.
3. Компанийн дүрмийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Улсын бүртгэлд бүртгүүлэх, Санхүүгийн зохицуулах хороо, бусад эрх бүхий байгууллагад хүргүүлэх, нийтэд мэдээлэхтэй холбоотой арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Х.Тэгшээ)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



С. САНАСЭР

**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 09 сарын 18

№ 2

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дүгээр зүйлийн 62.1.13 дахь заалт болон 2024 оны 09 сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсвийг нийт 600,000,000 төгрөгөөр баталсугай.
2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Цалин урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



С. САНАСЭР

**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 09 сарын 18

№ 3

Улаанбаатар хот

**Эм жи эл акуа ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт болон Эм жи эл акуа ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 09 сарын 18-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд олонхийн санал авсан:
Ердийн гишүүдэд:

1. С.Алтантуяа
2. Х.Тэгшээ
3. Б.Ундрал
4. О.Сансар /Shansier/
5. Л.Билгүүн
6. М.Дөлгөөн

Хараат бус гишүүдэд

1. Д.Басандорж
2. С.Санасэр
3. Ч.Анхбаяр

нарыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА



С. САНАСЭР